| | **1-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах; | БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/426 дугаартай тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулж, тендерийг KfW банкны Үндэсний тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/562 дугаар тушаалаар "Гэрээ байгуулах эрх олгох, хөрөнгө гаргах" тушаалыг батлуулж, тендерт шалгарсан "Хилийн цэргийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-тай 694,540 еврогийн үнийн дүн бүхий 22/373 дугаар гэрээг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан. Гүйцэтгэгчээс 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн гэрээний хугацаа сунгах хүсэлтийг хүлээн авч үндэслэлтэй гэж үзэн гэрээний хугацааг 60 хоногоор буюу 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд сунгаж Гэрээний нэмэлт №1-ийг байгуулав. Гэрээний дагуу БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны А/41 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг эхний гүйцэтгэл буюу 10 нэр төрлийн 7358 ширхэг хувцас хэрэглэлийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 2023/01 дугаар актаар хүлээн авсан ба төсөлд хамрагдсан 32 байгууллагад батлагдсан хуваарилалтын дагуу актаар хүлээлгэн өгч эхний санхүүжилт буюу гэрээний үнийн дүнгийн 60%-ийг нийлүүлэгчид олгосон. Гэрээний дагуу эцсийн гүйцэтгэл буюу 7 нэр төрлийн 4637 ширхэг иж бүрэн хувцсыг мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр ажиллаж, 2023/06 дугаар актаар хүлээн авч төсөлд хамрагдсан 32 байгууллагад батлагдсан хуваарилалтын дагуу дэд актаар хүлээлгэн өгснөөр гэрээг дүгнэн эцсийн санхүүжилтийг олгов. ***Ажлын гүйцэтгэл 100%.***<br>*Ажлын үр дүнд Төсөлд хамрагдсан сумдын БХ, БО-ны хяналтын улсын байцаагчид болон бусад ТХГН-ийн Хамгаалалтын захиргааны 919 хүний оффисын болон хээрийн ажлын зориулалт бүхий 4 улирлын 17 нэр төрлийн иж бүрэн 11995 ширхэг дүрэмт хувцсаар хангагдсанаар нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдаж, шинэ өнгө төрх, эрч хүчтэйгээр ажил үүргээ гүйцэтгэх болов.*<br><br>**7. Хамгаалалтын захиргааны байрны хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 1.07/:**<br>Төслийн зөвлөх багаас Хамгаалалтын захиргааны байрны хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, 9 Хамгаалалтын захиргааны байр шинээр барих, нэг загварын оффисын барилгын хэрэгцээ, шаардлагыг гаргах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төслийн 2024 оны төлөвлөгөөнд төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой. 50%** /2023.08-11 сард санхүүжүүлэгч байгууллагаар батлуулсан байхаар төлөвлөгөөнд туссан./ |

| | | |
|---|---|---|
| | **1-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах; | **8. Хамгаалалтын захиргаадын барилгын нэмэлт ажлын концепц боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 1.08/:** Төслийн зөвлөх багаас Хамгаалалтын захиргааны байрны хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, 5 Хамгаалалтын захиргааны байрны барилгыг засах, (халаалт, цэвэр, бохир усны шугам, барилгын дулаалга) засварын ажлын зураг төсөл, зардлын тооцоог хийх ажлыг үргэлжлүүлэн хийхээр төслийн 2024 оны төлөвлөгөөнд төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 100% /**2023.08-11 сард санхүүжүүлэгч байгууллагаар батлуулсан байхаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**9. Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.09./:** 2022 онд байгуулсан 330,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202202013, 22/178 дугаартай тус шатчилсан гэрээт ажлыг "Некст степ инженеринг" ХХК нь 2022 оны 08 дугаар сарын 01 өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр гэрээнд заасан байдаг.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайлан, Хустайн БЦГ-ын ХЗ-ны байгаль хамгаалагч, судлаачдын байрны засварын ажлын даалгавар, 2 удаагийн хяналт тавьсан тайланг ирүүлсний дагуу гүйцэтгэгчийн эхний санхүүжилтийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр шийдвэрлэж олгосон.<br>Гэрээний дагуу тайлангийн хугацаанд жилийн ажлын төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлж гүйцэтгэлийг үнэлэх ба гэрээний ерөнхий нөхцөлийн 3 дугаар бүлгийн 3.1 болон 3.2 дахь заалт, гэрээний тусгай нөхцөлийн 8.1 дүгээр заалт, гэрээний баримт бичгийн 3 дугаар хавсралтын 5 болон 14 дүгээр заалтыг тус тус мөрдөж, хамтран ажиллахыг төслийн зохицуулагчийн 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 37/23 дугаар албан бичгээр мэдэгдэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг удаа дараа шаардсан боловч хариу арга хэмжээ аваагүй, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй тул Захиалагчаас Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний ерөнхий нөхцөлийн 4.4.1 дэх заалтын дагуу гэрээ цуцлах үндэслэл бүрдсэн болохыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 08/3830 дугаар албан бичгээр мэдэгдэж, гэрээний ерөнхий нөхцөлийн 4.4.5-д заасан арга хэмжээг авч, хариуг 2023.08.07-ны дотор ирүүлэхийг мэдэгдэж үр дүн гараагүй тул гэрээний ерөнхий нөхцөлийн 4.4.1 дэх заалтын дагуу гэрээг 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон цуцалж, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 03/4619 дугаартай албан бичгээр мэдэгдсэн. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.** |

| | | |
|---|---|---|
| | | **10. Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.10./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/68 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулагдсаны ажлын даалгаврыг захиалагчаар 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр батлуулсан. Тендерийг тус сарын 18-ны өдөр зарласан хэдий ч нэг ч компани саналаа ирээгүйтэй холбогдуулан ажлын даалгавар, концепцийг төслийн зөвлөх баг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр танилцуулахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 30% хоцрогдолтой** /2023.08 сард гэрээ байгуулахаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 1-ийн хүрээнд нийт 10 ажил төлөвлөснөөс 1 ажил цуцлагдсан тул үнэлэхгүй, 4 ажил 100%, 1 ажил 70%, 3 ажил 50%, 1 ажил 30%-тай үнэлэгдэж байна.** Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын гэрээг захиалагч талын шийдвэрээр цуцалсан тул үнэлэхгүй./1.09/<br>ОБЗЭС-ийн үнэлгээ /1.01/, ХЗ-дын байрны болон үгдсэн тоног төхөөрөмж, дүрэмт хувцасны хэрэгцээ шаардлагын судалгаа хийх төслийн зөвлөх багийн хариуцсан 2 ажил /1.07, 1.08/, байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах болон ЮНЕСКО-д зарим ТХГН-ийг бүртгүүлэх 2 ажил /1.03, 1.10/, нийт 5 ажил /30-70%/ хоцрогдолтой байна.<br>**Зорилт 1-ийн ажлын дундаж үнэлгээ 72,2 %.** |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга-Хөдөлмөр эрхлэлт ба гараааны бизнес*<br>*3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залуust бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/*<br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт*<br>*3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.*<br><br>**1. Төслийн II/III үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>Үнэлгээний хороо байгуулах тухай тушаал Захиалагчаар баталгаажиж байна. Төслийн зөвлөх баг ажлын даалгаврын |

| | | |
|---|---|---|
| | | төслийг боловсруулан KfW-аар хянуулахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2023.11 сард эхэлж, 2024.12 сар хүртэл үргэлжлэхээр төлөвлөгөөнд туссан./<br><br>**2. Баруун бүсийн ТХГН-ийн орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.02, 3.01/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.01-д төлөвлөсөн "Төслийн I үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх" зөвлөх үйлчилгээний ажлын үнэлгээ, тайлангийн үр дүнд үндэслэн хэрэгжихээр төлөвлөгдсөн ч дээрх гэрээт ажлын гэрээний хугацаа сунгагдсантай холбогдуулан тус ажил хойшлогдож, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.10 сард эхэлж, 2024.12 сар хүртэл үргэлжлэхээр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.2.Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**3. Уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч Монгол Алтайн уулсын өндрийн бүс, бүслүүрийн дагуу ургамлан бүлгэмдлийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/205 дугаартай гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай тушаалын дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Математик, байгалийн ухааны сургуультай 58,800,000.0 төгрөгийн үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайланг 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр ирүүлснийг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 2023/05 дугаартай актаар хүлээн авч, эхний санхүүжилт буюу гэрээний үнийн дүнгийн 40%-ийг олгосон. Гүйцэтгэгч нь ажлын даалгаврын дагуу Монгол Алтайн уулсын өндрийн бүс бүслүүрийн дагуу ургамлан бүлгэмдлийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлж ашиглалтад өртөмтгий 50 зүйл ургамлын тархац нөөцийг тогтоон уур амьсгалын өөрчлөлтийг илэрхийлэх 5 зүйл ургамлын тархал нөөцийн хэтийн төлөвийг тодорхойлох хээрийн болон суурин судалгааны ажлыг гүйцэтгэж, зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 22- |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | ны өдөр БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны А/65 дугаар тушаалаар томилогдсон “Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, тайланг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2023/11 дугаартай актаар хүлээн авсан тул гэрээг дүгнэж эцсийн санхүүжилтийг олгохоор ажиллаж байна. ***Ажлын гүйцэтгэл 100%.***<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*i. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.20. <u>Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах,</u> хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.*<br><br>**4. Бэлчээр, ой, амьжиргаа сайжруулах ажлуудын менежментийг дэмжих ажлын хүрээнд /ҮАТ 2.04/:**<br>Төслийн зөвлөх багаас бэлчээр, ойн менежментийн концепци боловсруулах Зөвлөх багийн богино хугацааны үндэсний зөвлөх Др. Б.Эрдэнэбаатар, Б.Оюунцэцэгийг 2023 оны 05 дугаар сарын 20, Др. Н.Хонгорыг тус оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс тус тус гэрээ байгуулан ажилласны дүнд төслийн 2024 оны төлөвлөгөөнд холбогдох загвар төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>*Богино хугацааны зөвлөхүүд нь бэлчээр, ойн менежментийн концепцийг боловсруулж Орчны бүсийн 3 хүртэлх суманд хэрэгжүүлэх бэлчээрийн загвар төсөл, Хан Хөхийн ДЦГ-т ойн загвар төсөл, баруун бүсийн сонгогдсон амьжиргаа дэмжих, шууд хөрөнгө оруулалтын 3-4 загвар төслийг тус тус хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан.*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил*<br>*2.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.* |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | **5. Баруун бүсийн ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим"-ыг сургалтын гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 2.05, 3.03/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/76 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03/4016 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Байгаль орчны мэдээлэл сургалтын төв" ТББ-тай 737,888,750.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/159 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу Баруун болон Говийн бүсийн төсөлд сонгогдсон 19 хамгаалалтын захиргааны хариуцах 38 тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд орших 75 сумын ерөнхий боловсролын 75 сургуулийг хамруулан “Эко танхим”-д хэрэглэгдэх сургалтын гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн багаж хэрэгслээр бүрэн хангаж актаар хүлээлгэн өгсөн ба аргазүйн сургалтыг Улаанбаатар хот болон 5 аймгийн төвд тус тус зохион байгуулж эцсийн тайланг ирүүлсний дагуу санхүүжилтийг олгоод байна.<br>**Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**6. Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.06, 3.04/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр А/48 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулсны дагуу тендерийн ажлын даалгавар 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр захиалагчаар батлагдсан. Тендерийн үнэлгээний хорооны 01 хурлыг тус сарын 25-ны өдөр зохион байгуулж, тендерийн баримт бичгийг захиалагчаар 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр батлуулан тендерийг тус сарын 05-ны өдөр зарлаж, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авсны дагуу тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/245 дугаартай гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай тушаалын дагуу "Хашхан" ХХК-тай 480,315.61 еврогийн үнийн дүн бүхий 23/161 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан. Гэрээний дагуу нийлүүлэх 9 нэр төрлийн 3225 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг үйлдвэрлүүлэн тээвэрлэлтэд шилжүүлж, Хашхан ХХК-аас ирүүлсэн эхний санхүүжилтийн хүсэлтийг шалгаж баримт бичгийн бүрдэл дутуу байгааг мэдэгдээд |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | гүйцээж ирүүлснээр санхүүжилт олгох болно гэж хэлээд санхүүд 2023.11.21-ний өдөр шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2024.03 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.5. <u>Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</u>*<br><br>**7. Цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.07/:**<br>"Ай Ти Эс Өү" ХХК-тай 2022 онд байгуулсан 574,147,000 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202207044, №22/322 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ажиллаж тоног төхөөрөмжийн техникийн шаардлага болон гэрээнд тусгагдсан нөхцлийн дагуу шалгаж 2023/02 дугаартай актаар хүлээн авсан.<br>Батлагдсан хуваарийн дагуу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Баянхонгор, аймгийн БОАЖГ-т 3 нэр төрлийн 15 ш, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий аймгийн сумдад 3 нэр төрлийн 95 ш, Говь-Алтай аймгийн ИТХ, Увс аймгийн ЗДТГ тус тус 4 нэр төрлийн 4 ш, БОАЖЯ 2 төрлийн 2ш зэрэг нийт 7 нэр төрлийн 120 ширхэг ухаалаг дэлгэц, дууны өсгөгч, ухаалаг дэлгэцийн хөл, вэб камерийн ком, лед дэлгэц, лед дэлгэцийн удирдлага, зөөврийн компьютер зэрэг цахим хурлын тоног төхөөрөмжийг 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 16 хоногийн хугацаанд баруун 5 аймаг, 30 сум тус бүрд тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан шалгаж, нийт 38 байгууллагын 159 албан хаагчид тоног төхөөрөмжийн танилцуулга хийж, цаашдын ашиглалттай холбогдох заавар, зөвлөмж өгч сургалт зохион байгуулсан ба гарын авлага материалаар хангасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>*Тус ажлын үр дүнд төвөөс алслагдсан аймаг, сумдын төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт хурал уулзалт, сургалтын арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаг хугацаа, зардал хэмнэх боломжуудыг бүрдүүлсэн.*<br><br>**8. Байгаль орчны байгууллагуудад болон сонгогдсон 7 хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх ажлын хүрээнд (ҮАТ 2.08, 3.05):**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 03/3855 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Майнс ап" ХХК-тай 792,000.0 еврогийн үнийн дүн бүхий 23/150 дугаартай гэрээг 2023 оны 07 дугаар |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:** **Хүрэх үр дүн:** Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | сарын 31-ний өдөр байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 16 ширхэг Ниссан Патрол У61 Grx загварын автомашинуудын үйлдвэрлэлийн процесс дуусаж, далайн тээврийн ачилт эхлэх хуваарийг хүлээж байна.<br>БНХАУ-ын Шинганг далайн боомтод задгай тээврээр ирсэн ачаа, бараануудад Улаанбаатар болон бусад эцсийн чиглэл рүү тээвэрлэлт хийх чингэлгийн хүрэлцээгүйгээр ачаа тээврийн үйл явц энгийн үеийнхээс 2-3 дахин удаашралтай явагдаж байгааг нийлүүлэгчээс мэдэгдэж 2 удаагийн уулзалт зохион байгуулсан ба 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн АБ-23/1062 дугаартай албан бичгээр гэрээний хугацааг 90 хоногоор буюу 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл сунгах хүсэлтийг захиалагчид ирүүлээд байна. Захиалагчаас хараахан шийдвэр гараагүй судалж байна. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 70%.** /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>9. **Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, трактор, хогны машин, бохир соруулах машин) ажлын хүрээнд /ҮАТ 2.09, 3.06/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/46 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдсаны дагуу ажлын даалгаврыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр батлуулсан.<br>**Багц 1:** БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 03/4485 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Протек" ХХК-тай 183,709.0 еврогийн үнийн дүн бүхий 23/177 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд завь, 4 дугуйт мотоцикл нийлүүлэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 3 төрлийн 19 ширхэг завь болон 3 ширхэг дөрвөн дугуйт мотоцикл, 275 ширхэг дагалдах тусгай хэрэгслийн захиалгууд хийгдэж үйлдвэрлэл явагдан дусаж байна. Хуваарийн дагуу 2023 онд багтаан тээвэрлэлтэд шилжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%**<br>**Багц 2:** БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 03/4484 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "МБ Инженеринг" ХХК-тай 471,327.0 еврогийн үнийн дүн бүхий 23/178 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд гэрээний дагуу нийлүүлэх 11 ширхэг өөрөө буулгагч автомашин, 4 ширхэг бохир соруулах автомашин, 7 ширхэг трактор, дагалдах 22 ширхэг агрегат, тоног төхөөрөмжийг үйлдвэрлүүлэн тээвэрлэлтэд шилжүүлсэн |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | байна. Гэрээний дагуу машин, тоног төхөөрөмжийг тээвэрлэлтэд шилжүүлсэн баримт бичигт үндэслэн эхний санхүүжилтийг олгоод байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2024.04 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br>**Багц 1 болон Багц 2-ын ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**10. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.10, 3.07/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 03/5774 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Мөнххада" ХХК-тай 935,000.0 еврогийн үнийн дүн бүхий 23/249 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>“Мөнххада” ХХК-аас гэрээний хүрээнд нийлүүлэх тоёота Ланд круйзер LC78 загвар (бензин)-ын 17 ширхэг автомашиныг нийлүүлэх боломжгүй болсон тухайгаа 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 02/930 дугаар албан бичгээр мэдэгдсэн. Гэрээний дагуу нийлүүлэх 17 ширхэг автомашиныг 2025 оны захиалгад шилжүүлж болох хэдий ч урьдчилан төлөвлөх боломжгүй ба тоёота Ланд круйзер LC78 дизель загвараар сольж нийлүүлэх хүсэлтэй байгааг судалж үзэхийг хүссэн. Энэхүү хүсэлтийн хүрээнд захиалагчаас ямар нэгэн шийдвэр гараагүй байна. ***Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%.*** */2024 оны 06 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.5. <u>Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</u>*<br><br>**11. Баруун бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.11, 3.08/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/70 дугаар тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. БОАЖЯ 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хуваарилалтыг баталсны дагуу тендерийг тус сарын 29-ний өдөр зарлаж, 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 03/4574 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Протек" ХХК-тай 1,127,225,600.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/172 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 200 ширхэг Yamaha YBR-125EGS загварын мотоцикл тээвэрлэлтэд шилжсэн ба 2023 оны 12 сарын 22-нд гаалийн талбайд буух төлөвлөгөөтэй байгаа ба мотоциклд дагалдах хамгаалалтын хэрэгсэл болох 200 ширхэг дуулга, 200 ширхэг өвдөгний хамгаалалт гаалийн талбайд бэлэн ирсэн тул баримт бичгийг үндэслэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлсэн. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2024.03 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.2. Орон сууцны чанар, стандартыг хангаж, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.*<br>*2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**12. Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, үзэл баримтлалыг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.12/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/378 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан. Төслийн зөвлөх багаас ажлын даалгаврын төслийг IC зөвлөх баг боловсруулж KfW-д хянуулж зөвшөөрөл авахаар хүргүүлсэн болович санхүүжүүлэгч талаас ажлын даалгаврыг зөвшөөрөөгүй тул тус ажил хойшлогдож, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.08 сард эхэлж,12 сард тайланг хүлээн авахаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**13. Баруун бүсийн ССМТ-ийн барилгын ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.13/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.12-д төлөвлөсөн "Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийж, үзэл баримтлалыг боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын тайлан үр дүнд уялдан хийгдэх байсан тул дээрх ажил хойшлогдсонтой холбогдуулан, хийгдээгүй, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.11 сард ажлын даалгаврыг боловсруулсан байхаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**14. Монгол Элсний ТХГН-т хамаарагддаг Эрээн нуурыг сэргээх ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажлын хүрээнд /ҮАТ 2.14/:** |

| | | |
|---|---|---|
| | | Тус ажлыг захиалагч тал монголын талын хөрөнгө оруулалтаар хийхээр хэлэлцэж байгаатай холбогдуулан цуцлагдсан. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.*<br>*2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**15. Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн барилгын одоогийн зураг төсөв, зардлын тооцоог шинэчлэх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.15/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/377 дүгээр тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдсаны дагуу ажлын даалгаврыг 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлуулсан. Тус ажил нь барилгын зургийн авторын эрхтэй ажил тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг БОАЖЯ-ны ТНБД-д 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр танилцуулж, 14-ний өдөр захиалагч талаас зөвшөөрөл авсны дагуу "Бьюлдингс Технөложи" ХХК-д 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээний төслийг хүргүүлэв. Захиалагчаас Бьюлдингс Технөложи ХХК-д 2023.12.14-ний өдөр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээний төслийг хүргүүлэв. Захиалагч Бьюлдингс Технөложи ХХК-тай 2023.12.28-ны өдөр гэрээ байгуулсны дагуу зургийн ажлын даалгавар, А ажлын даалгавар болон ажлын нарийвчилсан төлөвлөгөө, эхлэлийн тайланг боловсруулж байна. Гэрээний дуусах хугацаа 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 70%** /2023.09 сард гэрээ байгуулахаар төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**16. Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих ажлын хүрээнд /ҮАТ 2.16/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.15-д төлөвлөсөн "Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн барилгын одоогийн зураг төсөв, зардлын тооцоог шинэчлэх" зөвлөх |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:** Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | |

| | | |
|---|---|---|
| | | үйлчилгээний ажлын тайлан үр дүнд уялдан хийгдэх байсан тул дээрх ажил хойшлогдсонтой холбогдуулан, хийгдээгүй, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.12 сард гэрээ байгуулсан байхаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**17. Баруун бүсийн ТХГН-т байгаль хамгаалагчийн 12 байр барих ажлын хүрээнд /ҮАТ 2.17/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10-т төлөвлөсөн "Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын тайлан үр дүнд уялдан хийгдэх байсан тул дээрх ажил хойшлогдсонтой холбогдуулан, хийгдээгүй, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.12 сард гэрээ байгуулсан байхаар төлөвлөгөөнд туссан./ |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; | **Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 2-ын хүрээнд нийт 17 ажил төлөвлөснөөс 1 ажил цуцлагдсан тул үнэлэхгүй, 9 ажил 100%, 2 ажил 70%, 5 ажил хийгдээгүй 0%-тай үнэлэгдэж байна.**<br>Эрээн нуурыг сэргээх ажил улсын төсвийн санхүүжилтээр хийгдэхтэй холбогдуулан цуцлагдсан тул үнэлэхгүй. /2.14/<br>Үүнээс ГИДЦГ-ын барилгын зураг /2.15/, бартаат замын автомашин нийлүүлэх /2.08/ зэрэг 2 ажил хоцрогдолтой.<br>Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийх ажил явагдаагүйгээс барилгын зураг төсөл боловсруулах ажил давхар хийгдээгүй. /2.12, 2.13/<br>Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн барилга барих ажил /2.16/ барилгын одоогийн зураг төсөв, зардлын тооцоог шинэчлэх ажил /2.15/ хойшилсноос болж хийгдээгүй, байгаль хамгаалагчийн 12 байр барих гэсэн барилгын ажил /2.17/ нь "Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажил /1.10/ хийгдээгүйгээс шалтгаалан 2024 оны төлөвлөгөө рүү орсон.<br>ОБЗЭС-ийн санхүүжилтийг шилжүүлэх ажил /2.02/ тус ажлын зөвлөхийн гэрээг санхүүжүүлэгч байгууллагаас сунгах чиглэл өгсний дагуу 2024 он руу шилжсэн.<br>**Зорилт 2-ын ажлын дундаж үнэлгээ 61,9 %.** |
| | | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга-Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес*<br>*3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт*<br>*3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс* |

| | | |
|---|---|---|
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:** .<br>Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; | *санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.*<br><br>**1. Сонгогдсон 7 хамгаалалтын захиргааны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.02, 3.01/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.01-д төлөвлөсөн "Төслийн I үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх" зөвлөх үйлчилгээний ажлын үнэлгээ, тайлангийн үр дүнд үндэслэн хэрэгжихээр төлөвлөгдсөн ч дээрх гэрээт ажлын гэрээний хугацаа сунгагдсантай холбогдуулан тус ажил хойшлогдож, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.10 сард эхэлж, 2024.12 сар хүртэл үргэлжлэхээр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.*<br><br>**2. Сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд: /ҮАТ 3.02/:**<br>Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуультай 2022 онд байгуулсан 65,880,000 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-22/22, 22/278 дугаартай гэрээний дагуу сонгогдсон 3 ТХГН-ийн түлхүүр зүйлүүдийн суурь мэдээллийг бүрдүүлэх талбай, арга зүй, үр дүнг нэгтгэх, тайлагнах ажлын талаарх төлөвлөгөө буюу эхлэлийн тайланг хүлээн авснаар эхний санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байсан. Тус онд гэрээний дагуу Говь Гурван сайханы БЦГ-т Цоохор ирвэс, Аргаль хонь, Хар сүүлт, Их газрын чулууны БЦГ-т Аргаль хонь, Монгол тарвага, Дарьгангын БЦГ-т Аргаль хонь, Монгол Тарвага, Цагаан зээрийн биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн тархалт, нөөц, сүргийн бүтэц, нүүдэл шилжилт хөдөлгөөн (эко коридор) нутгуудыг тодорхойлох суурь мэдээллийг бүрдүүлэх хээрийн судалгааны ажил болон суурин боловсруулалын ажил дуусч, тайланг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ТХН-д ирүүлээд байна. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 дугаар тушаалаар томилогдсон БОЯБ-ын мэргэжлийн зөвлөл нь тус ажлын тайланг хэлэлцэх зөвлөлийн хурлыг 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу |

| | | |
|---|---|---|
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; | гэрээг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дүгнэсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>*Тус ажлын үр дүнд тогтоосон шалгуурын дагуу сонгосон 7 УТХГ буюу Говийн бага ДЦГ, Нөмрөгийн ДЦГ, Их газрын чулууны БЦГ, Дарьгангын БЦГ, Их Богдын БЦГ, Монгол элсний БЦГ, Говь гурван сайхны БЦГ-ын биологийн олон янз байдлын суурь судалгаа бүрдэж байна.*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил*<br>*2.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.*<br><br>**3. Сонгогдсон ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим"-ыг сургалтын гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 2.05, 3.03/:**<br>Тус ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.05-д төлөвлөсөн Баруун бүсийн ТХГН-ийн орчны бүсийн сумдын сургуулийн "Эко танхим"-ыг сургалтын гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалт зохион байгуулах ажилтай хамтатган зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**4. Сонгогдсон ТХГН-ийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.06, 3.04/:**<br>Тус ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.06-д төлөвлөсөн Баруун бүсийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажилтай хамтатган зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2024.03 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**5. Сонгогдсон 7 хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.08, 3.05/:**<br>Тус ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.08-д төлөвлөсөн Баруун бүсийн хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх ажилтай хамтатган |

| | | |
|---|---|---|
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; | зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 70%.** /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**6. ТХГН-ийн 7 ХЗ-г бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, трактор, хогны машин, бохир соруулах машин) ажлын хүрээнд /ҮАТ 3.06, 2.09/:**<br>Тус ажлын тендерийг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.09-д төлөвлөсөн “Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах” ажилтай хамтатган зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%.**<br><br>**7. ТХГН-ийн ОБ-ийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажлын хүрээнд /ҮАТ 3.07, 2.10/:**<br>Тус ажлын тендерийг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.10-т төлөвлөсөн “ТХГН-ийн ОБ-ийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах” ажилтай хамтатган зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%.** /2024 оны 06 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**8. Сонгогдсон ТХГН-ийн ХЗ-дыг мотоциклоор хангах ажлын хүрээнд /ҮАТ 3.08, 2.11/:**<br>Тус ажлын тендерийг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.11-д төлөвлөсөн “**Баруун бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах**” ажилтай хамтатган зохион байгуулж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2024.03 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**9. Сонгогдсон ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын 13 байгаль хамгаалагчийн байр барих ажлын хүрээнд /ҮАТ 3.09, 2.17/:**<br>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10-т төлөвлөсөн “Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын тайлан үр дүнд уялдан хийгдэх байсан тул дээрх ажил хойшлогдсонтой холбогдуулан, хийгдээгүй, он дамжин төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл хийгдээгүй 0%** /2023.12 сард гэрээ байгуулсан байхаар төлөвлөгөөнд туссан./<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 3-ын хүрээнд нийт 9 ажил төлөвлөснөөс 6 ажил 100%, 1 ажил 70%, 2 ажил 0%-тай үнэлэгдэж байна.**<br>Байгаль хамгаалагчийн 13 байр барих гэсэн барилгын ажил /3.09/ нь “Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах” /1.10/ зөвлөх үйлчилгээний ажлаас шалтгаалан хийгдээгүй.<br>ОБЗЭС-ийн санхүүжилтийг шилжүүлэх ажил тус ажлын /3.01/ зөвлөхийн гэрээг санхүүжүүлэгч байгууллагаас сунгах чиглэл өгсний дагуу 2024 он руу шилжсэн. |

| | | |
|---|---|---|
| | | **Зорилт 3-ын дундаж үнэлгээ 68,9%.** |
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | **1. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний чуулган зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.01/:**<br>Байгаль хамгаалагч нарын II чуулганыг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсантай холбогдуулан доорх ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br><br>• Үндэсний чуулганы хөтөлбөрт төслийн зүгээс оруулах саналыг тусгасан. /2023.10.20/<br>• Төслийн Тусгай гэрээнд Германы буцалтгүй тусламжаар санхүүжүүлэгдэх үйл ажиллагааны төрлүүдийг төслийн Бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр зааж, удирдлагад танилцуулсан. /2023.10.26/<br>• Чуулганы үеэр төслийн танилцуулгыг хийхтэй холбогдуулан PPT-ийг шинэчилж удирдлагад илгээсэн. /2023.10.27/<br>• Чуулганы үеэр ХЗ-ны дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас асуух QR санал, асуумжийг бэлтгэсэн. /2023.10.25/<br>• Чуулганы нийт 550 оролцогч нарын нэрийг тулгаж, мандат дээр бичиж, төрийн тусгай хамгаалалтын газраар тамгалуулан тараасан. /2023.11.23-25/<br>• Чуулганыг зохион байгуулахад оруулсан хувь нэмрийг үнэлэн БОАЖ-ын сайдын нэрэмжит шагналаар ТХН шагнуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**2. Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, стандарт боловсруулах уулзалт зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-наас чиглэл өгөөгүйтэй холбогдуулан тус ажлыг 2024 он руу шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>3. **Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 10 дугаар сарын 02-ны А/320 тоот тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу ажлын даалгаврыг 2023 оны 11 дүгээр сарын 15-нд батлуулсан. Үнэлгээний хорооны №01 тоот хурлыг 2023 оны 12 дугаар сарын 06-нд хийхэд үнэлгээний хорооны дарга болон гишүүн тендерийн үнэлгээний хороонд ажиллахаас татгалзсантай холбоотойгоор үнэлгээний хорооны тушаалд өөрчлөлт орох тушаалын төсөл холбогдох дарга нарт танилцуулагдаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%** /2023.10 сараас эхэлж 2024 оны 12 сар дуустал хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд туссан/ |

| | | |
|---|---|---|
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | **4. Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх контент боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 4.04/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/71 дугаар тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгаврыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 03/5861 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "И Эм Технологи" ХХК-тай 50,100,000.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/259 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ирүүлснийг тайлан хүлээн авах актаар баталгаажуулан, эхний санхүүжилт буюу гэрээний үнийн дүнгийн 40%-ийг олгосон. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 70%.** /2023.11 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**5. ТХГН-ийн шинэлэг менежмент судлах олон улсын туршлага судлах ажлын хүрээнд /ҮАТ 4.05/:**<br>ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны явцын үнэлгээний баг 2023 оны 06 сард Монголд ажилласан томилолтын үр дүнд гарсан хурлын тэмдэглэлд: “БОЯБХУАӨДЗТ-ийн санхүүжилтээс санхүүжих аливаа аялал нь тодорхой санал дээр тулгуурласан байх ба KfW-ээс үл татгалзах авна.” гэсний дагуу туршлага судлах аяллын хэрэгцээ, агуулга, зорилгыг БОАЖЯ-наас тодорхойлж Сэргээн босголт, зээлийн (KfW) банканд хүргүүлэхээр тохирсон. Санхүүжүүлэгч байгууллага туршлага судлах аяллын зорилго, зорин очих газар, аялалд оролцох хүмүүсийн талаар тодорхой мэдээллийн захиалагчаас хүссэний дагуу чиглэл аваагүйтэй холбогдуулан тус ажлыг 2024 он руу шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>**6. ТХГН-ийн мэдээллийн сангийн сүлжээ серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 4.06/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 03/6085 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Ай Ти Зон" ХХК-тай 146,521,400.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/279 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага нь 3 төрлийн серверийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн угсарч суурилуулах ажлыг гүйцэтгэх ба 1-р бараа буюу сервер компьютерыг үйлдвэрт захиалсан байна. 2, 3-р бараа буюу |

| | | |
|---|---|---|
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | сүлжээний хамгаалалтын төхөөрөмж, тог баригчийг өөрийн агуулахад бэлэн ирүүлээд байна. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 70%.** /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**7. Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.07/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/321 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу ажлын даалгаврыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан. Үнэлгээний хорооны №01 тоот хурлыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Тус ажил нь зохиогчийн эрхтэй ажил тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг БОАЖЯ-ны ТНБД-д 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр танилцуулж, тухайн өдөр зөвшөөрөл авав. Захиалагчаас 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр зохиогчийн эрхтэй хуулийн этгээд рүү хамтран ажиллах тухай урилга хүргүүлсэн ба тус урилгын төслийг боловсруулсан. Зохиогчийн эрхтэй хуулийн этгээдээс 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр "Бит Софт" ХХК-д хариу албан бичиг илгээсэн ба зохиогчийн эрхийн гэрчилгээ болон бусад холбогдох баримтын хамт ирүүлснийг хянан шалгаж байна. Гэрээг 2024 оны 01 дүгээр сард багтаан байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 50%.** /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>*Тус ажлын үр дүнд Монгол орны ТХГН-ийн сүлжээний нэгдсэн цахим хуудас www.mpa.gov.mn болон 33 хамгаалалтын захиргаадын цахим хуудасны загвар дизайныг сайжруулах, шинээр байгуулагдсан 7 хамгаалалтын захиргааны цахим хуудсыг шинээр хийх болно.*<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 4-ийн хүрээнд нийт 7 ажил төлөвлөснөөс 2 ажил захиалагч талаас шалтгаалан хойшилсон тул үнэлэхгүй, 2 ажил 100%, 2 ажил 70%, 1 ажил 50%-тай үнэлэгдэж байна.**<br>ТХГН-ийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, стандарт боловсруулах уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, ТХГН-ийн шинэлэг менежмент судлах олон улсын туршлага судлах 2 ажил /4.02, 4.05/, захиалагч талаас шалтгаалан хойшилсон тул үнэлэхгүй.<br>ТХГН-ийн мэдээллийн сангийн сүлжээ серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх /4.06/ хоцрогдолтой /70%-тай/, Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах ажил /4.07/ хоцрогдолтой /50%-тай/ байна.<br>**Зорилт 4-ийн дундаж үнэлгээ 78%.** |

| | | |
|---|---|---|
| 7 | Төслийн ерөнхий менежмент | **1. 2024 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлын хүрээнд /PM01/:**<br>Төслийн 2024 оны үйл ажиллагааг төлөвлөж дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>• Захиалагч талын хэрэгцээ шаардлагыг үндэслэн тулгамдсан ажлуудыг ирэх онд хэрэгжүүлэхээр төслийн 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 87/23 дугаартай "Санал ирүүлэх тухай" албан бичгийг БОАЖЯ-ны ТХГНБЗГ-т хүргүүлсэн.<br>• БОАЖ-ын сайдын зөвлөх, тус яамны холбогдох газрын дарга нартай 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан хуралд оролцож, хэлэлцсэн асуудлын тэмдэглэлийг гаргаж, удирдлагад танилцуулсан. /2023.10.23/<br>• 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зөвлөх багтай хуралдаж, 2024 оны төлөвлөгөөний төслийг гаргасан.<br>• БОАЖЯ-наас 2024 оны төлөвлөгөөнд оруулах нийт 33 саналыг хүлээн авч, төслийн зорилго зорилгод нийцсэн байдлаар эрэмбэлж нэгтгэсэн.<br>• 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр БОАЖЯ, ТХН болон зөвлөх багийн хамтарсан уулзалтыг зохион байгуулахад оролцож, хурлын үеэр тавих танилцуулгыг бэлтгэсэн.<br>• 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр болон тус оны 12 дугаар сарын 01-ний өдөр ЗБ, ТХН-ийн ажилтан нарын хурлыг тус тус зохион байгуулж, төлөвлөгөөний төслийг эцэслэсэн.<br>• Төслийн УХ-ны хурлыг зохион байгуулснаар ҮАТ-ний төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, нийт 84 үйл ажиллагааг төлөвлөн УХ-ны даргаар батлуулахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. Төслийн 2022 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх, 2023 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх гэрээ байгуулах ажлын хүрээнд /PM02/:** Үндэсний аудитын газрын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1555 дугаартай албан тоотын дагуу төслийн I болон II,III шатны 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх ажлын №23/01, №23/02 дугаартай гэрээг "Интер аудит" ХХК-тай тус тус байгуулж ажилласны дагуу аудитын тайланг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газар хүргүүлсэн. Аудитын шалгалтаар төслийн I шатанд өөрчлөлтгүй дүгнэлт буюу 1 зөвлөмж, II шатанд өөрчлөлтгүй дүгнэлт буюу 3 зөвлөмжтэй аудитлагдаж санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн тайланд нэгтгэгдсэн.<br>"Төслийн 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх" ажлын гэрээг тус |

| | | |
|---|---|---|
| | Төслийн ерөнхий менежмент | онд багтан байгуулна. Ажлын тайланг 2024 оны 03 дугаар сард багтаан хүлээн авахаар төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%.**<br><br>**3. Төслийн Удирдах хорооны хурлыг зохион байгуулах ажлын хүрээнд /PM03/:**<br>Төслийн УХ-ны XVII хурлыг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Германы сэргээн босголт зээлийн банкны монгол дахь суурин төлөөлөгчийн газарт зохион байгуулж, шийдвэрлэх асуудлыг хэлэлцэж, төслийн 2023 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>4. **Төслийн хяналт үнэлгээний гарын авлага боловсруулах ажлын хүрээнд /PM04/:** Төслийн зөвлөх баг нь төслийн мониторинг үнэлгээний журам, аргачлалыг (DAC) буюу хөгжлийн шалгуур үзүүлэлт, KfW банкны журмын дагуу боловсруулах, төслийн үр дүн, бүтээгдэхүүний багцын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих тоон болон чанарын хэмжигдэхүүнийг шинээр тодорхойлох, төслийн 1 үе шатанд хэрэгжүүлсэн Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн орчны бүсийн зээлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх зэрэг ажлын даалгаврыг боловсруулсны дагуу мониторинг, үнэлгээний богино хугацааны үндэсний зөвлөх М.Нандинчимэгийг 2022 оны 12 сарын 05-ны өдрөөс 2023 оны 02 сарын 01-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаатай авч ажиллуулсан. Богино хугацааны зөвлөх нь төслийн үнэлгээ, мониторингийн журам, аргачлалыг эхний хувилбарыг боловсруулж, журмын төслийн явцыг төслийн зөвлөх багийнхантай удаа дараа хэлэлцсэний дүнд Үр дүнд суурилсан мониторинг (RBM), үнэлгээний системийг Дэлхийн Банкны үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн системд нийцүүлэн 7 үе шаттай аргачлалаар явцын болон нөлөөллийн мониторинг үнэлгээг хийхээр эцэслэн боловсруулсны дагуу мониторинг үнэлгээний аргачлалыг гаргаж, төслийн зөвлөх багаас 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тайлангаа танилцуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>*Энэхүү мониторинг үнэлгээний аргачлалын дагуу Төслийн хяналт, үнэлгээ хариуцсан зөвлөх, ТХН-ийн холбогдох ажилтан орон нутгийн ажилтнуудад чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.*<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинжлэх ухаан, инновац 2.4.12. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно.* |

| | | |
|---|---|---|
| | Төслийн ерөнхий менежмент | **5. Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөлийн хурлууд зохион байгуулах ажлын хүрээнд /PM05/:**<br>Тайлант хугацаанд БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан "Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөл"-ийн ээлжит хурлыг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж МУИС-ийн Шинжлэх ухааны их сургуультай байгуулсан 22/278 дугаартай "Сонгогдсон ТХГН-ийн биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх" зөвлөх үйлчилгээний гэрээний хүрээнд гүйцэтгэсэн эцсийн тайланг, 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургуультай байгуулсан "Уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч Монгол Алтайн уулсын өндрийн бүс, бүслүүрийн дагуу ургамлын бүлгэмдлийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх судалгааны зөвлөх үйлчилгээ"-ний хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын эцсийн тайланг тус тус хэлэлцэж, хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийг актаар хүлээн авав. Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2023 онд 2 удаа зохион байгуулж 2 тэмдэглэл үйлдэв. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**8. KfW банкнаас Төслийн явцын үнэлгээний баг ирж ажиллах ажлын хүрээнд /PM05/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны болон 10-ны өдөр, тус яамны ТХГНБЗГ-ын даргын 06 дугаар сарын 02-ны өдөр тус тус баталсан удирдамжийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрүүдэд ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны явцын үнэлгээний (Хангай, Говийн бүсийн) 1 дүгээр баг Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгуудад, (Худалдан авах ажиллагааны үнэлгээний) 2 дугаар баг (Байгаль орчин, нийгмийн менежментийн) 3 дугаар баг Улаанбаатар хот болон Төв аймагт,(Баруун бүсийн) 4 дүгээр баг тус оны 06 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд Баян-өлгий, Ховд аймаг, Говь-алтай аймгуудад тус тус томилолтоор ажиллаж, төслийн I шатанд хэрэгжүүлсэн Орчны бүсийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнтэй танилцан, үнэлгээ хийж, төслийн II, III шатны хэрэгжилт, 2022 оны ажлын үр дүнтэй танилцан, үйл ажиллагаанд тулгарч буй анхаарах асуудлуудыг шийдвэрлэж ажиллалаа. Удирдамжийн дагуу үнэлгээний ажлын тайланг тус тус гаргаж, илтгэх хуудасны хамт БОАЖЯ-ны холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Томилолтын хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 13-14-ний өдөр БОАЖЯ, Сангийн яам болон төслийг хамтран хэрэгжүүлж буй холбогдох талуудтай уулзалт, хэлэлцүүлгийг хийж, үнэлгээний үеэр тохирсон ажлуудыг БОАЖ-ын дэд сайд, төслийн УХ-ны дарга М.Ганбаатар, Германы сэргээн босголт зээлийн (KFW) банкны төслийн |

| | | |
|---|---|---|
| | | менежер Нина Отто нар гарын үсэг зуран, баталгаажуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний Төслийн ерөнхий менежментийн ажлын хүрээнд нийт 6 ажил төлөвлөснөөс 6 ажил 100% үнэлэгдэж байна. Төслийн ерөнхий менежментийн дундаж үнэлгээ 100%.** |
| 8 | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент, мониторинг | **1. Төслийн хүрээнд баригдах Говийн Б хэсгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, орчуулах ажлын хүрээнд /М01/:**<br>Төслийн хүрээнд баригдах Говийн Б хэсгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар сард боловсруулсан бөгөөд орчуулгын ажлыг тус онд багтаан дуусгахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 70%** /2023.09 сард хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд туссан./<br><br>2. **Говийн Б хэсгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын талбайд археологийн судалгаа хийх ажлын хүрээнд /М02/:**<br>IC Зөвлөх баг Археологийн хүрээлэнтэй 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 6,966,300 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулж, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр **барилгын талбайд археологийн судалгаа** хийсэн холбогдох бичиг баримтыг хүлээн авсан.**Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>3. **ТХН болон зөвлөх багийн ажилтнуудад шаардлагатай сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /М03/:**<br>Төслийн зөвлөх багийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент хариуцсан зөвлөхийг 2023 оны 11 сарын 05-ны өдрөөс нийт 15 ажлын хоногийн сургалтад танхимаар болон цахимаар хамруулснаар БОННМ-ийн талаар чадавхажсан болно. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>4. **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх /М04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03/4015 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн судалгааны төв" ТББ-тай 50,000,000.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/158 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайланг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад захиалагчаас хамааруулан хугацаа шаардлагатай байгаа тухай гүйцэтгэгчийн ирүүлсэн |

| | | |
|---|---|---|
| | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент, мониторинг | хүсэлтийг харгалзан үзэж “Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацаа”-г 30 хоногоор сунган 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл гэрээний хугацааг сунган гэрээний нэмэлт №1-ийг байгуулав. Гүйцэтгэгч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, санал тусгах, хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой бусад хуулийн төсөл, дагаж гарах журмын төслийг боловсруулж, танилцуулж санал, зөвлөмж, чиглэл тусгах ажлуудыг гүйцэтгэсэн тул Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газраас эцсийн тайланг хүлээн авахаар шийдвэрлэж, 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2023/10 дугаартай актаар зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн гэж үзэн хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулж санхүүжилтийг олгоод байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**5. Төслийн хяналт үнэлгээ, мониторингийн сургалт хийх ажлын хүрээнд /M05/:**<br>Санхүүжүүлэгч Германы сэргээн босголт зээлийн (KfW) банкнаас төслийн хяналт үнэлгээ, мониторингийн гарын авлага, матрицыг батлаагүй байгаатай холбогдуулан тус сургалтыг хойшлуулж, төслийн 2024 оны төлөвлөгөөнд төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний Мониторинг, байгаль орчин нийгмийн нөлөөллийн менежментийн ажлын хүрээнд нийт 5 ажил төлөвлөснөөс 1 ажил үнэлэхгүй, 3 ажил 100%, 1 ажил 70%-тай үнэлэгдэж байна.<br>**Төслийн Мониторинг, БОННМ-ийн дундаж үнэлгээ 92,5%.** |
| | Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн зардал | **1. ТХН, зөвлөх багийн албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 5.01/:**<br>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолтой холбогдуулан тус ажил хийгдээгүй. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>**2. БОЯБХУАӨДЗ Төслийн цахим хуудсыг шинэчлэх, мониторингийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 5.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 03/5872 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Идеадевелопмент" ХХК-тай 35,200,000.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/248 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага вэб сайтын загварын хувилбаруудыг боловсруулан ажлын нарийвчилсан төлөвлөгөөг танилцуулан эхлэлийн тайланг 2023 оны 12 |

| | | |
|---|---|---|
| 9 | Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн зардал | дугаар сарын 01-ний өдөр ирүүлснийг актаар баталгаажуулан, эхний санхүүжилт буюу гэрээний үнийн дүнгийн 40%-ийг олгохоор ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл хоцрогдолтой 70%.** /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**3. Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх ажлын хүрээнд /ҮАТ 5.03/:**<br>Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолтой холбогдуулан тус ажил хийгдээгүй. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл 2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.*<br><br>**4. Төсөл хэрэгжүүлэх зөвлөх багийн төлбөрийн ажлын хүрээнд /ҮАТ 5.04/:**<br>Төслийн хэрэгжүүлэгч зөвлөх багийн 2023 оны сүүлийн хагас жилийн санхүүжилт ҮАТ-нд заасан үнийн дүнгээр Германы сэргээн босголт зээлийн (KfW) банкнаас шилжсэн болно. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн ажлын хүрээнд нийт 4 ажил төлөвлөснөөс 2 ажил үнэлэгдэхгүй, 1 ажил 100%, 1 ажил 70% үнэлэгдэж байна. Төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн ажлын дундаж үнэлгээ 85%.** |
| | | **1. Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж БОАЖЯ, СЯ-д хүргүүлэх/ R01/:**<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Төслийн I болон II,III шатны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар тус тус гаргаж, төслийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/23 дугаартай албан бичгээр БОАЖЯ-ны УАӨБТГ-ын ГХАХ-т хүргүүлсэн.<br><br>Төслийн II,III шатны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар гаргаж, хагас жилийн байдлаар тус тус гаргаж, төслийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 63/23 |

| | | |
|---|---|---|
| 10 | Тайлан | дугаартай албан бичгээр БОАЖЯ-ны ТЗУГ-ын ГХАХ-т хүргүүлсэн.<br><br>Санхүүгийн ерөнхий тайлан:<br>• НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>• Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж байна.<br>• Хүн амын орлогын албан татварын тайланг сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хүргүүлж байна.<br><br>**2. Улирал, хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг KfW банканд илгээх/ R02/:**<br>Төслийн үйл ажиллагааны тайланг улирал тутамд KfW-банканд, худалдан авах ажиллагааны тайланг сар тутам БОАЖЯ-ны СХОХ-т, санхүүгийн үйл ажиллагаа, ашиглалтын тайлан мэдээг сар бүр СЯ-нд тус тус тайлагнасан.<br><br>**3. Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банкинд илгээх ажлын хүрээнд /R.03/:**<br>Төслийн II үе шатны татан авалтын тайланг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ХБНГУ руу хүргүүлсэн.<br><br>**4. Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх ажлын хүрээнд /R.04/:**<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан тушаал, шийдвэрүүдийг Шилэн данс, ODAMIS, eic.mn цахим системүүдэд оруулж ажилласан.<br><br>**5. Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, iec.mn, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх/ R04/:**<br>Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан тушаал, шийдвэрүүдийг Шилэн данс, ODAMIS, eic.mn цахим системүүдэд оруулж ажилласан. |
| 11 | Дүгнэлт (ололт, амжилт, дутагдал, анхаарах асуудлууд) | Цаашид анхаарах асуудлууд, дутагдал: Төслийн хүрээнд хийгдээгүй ажлууд дээр ХШҮ хийхэд зээлийн эргэлтийн сангийн санхүүжилт гаргах 2 ажлаас гадна баруун бүсийн төвийн барилгын концепц боловсруулах болон зураг төсөв гаргах 2 ажил, хамгаалалтын захиргааны байр барих 1 ажил, байгаль хамгаалагчийн байр барих 2 ажил, нийт 5 ажил барилгатай холбоотой байгаа нь ТХН-д барилгын мэргэжлийн зөвлөх шаардлагатай байгааг харуулж байна. Иймд ялангуяа барилгын ажлыг төлөвлөхдөө бэлтгэл ажлыг хангах, төсөв болон биелэлтийн хугацааг бодитоор тооцоолох, ажлын даалгаврыг чанартай боловсруулахад анхаарах шаардлагатай байна. |

<table>
<tr><td>12</td><td>Төслийг хэрэгжүүлэгч талуудын х/а-нд өгөх үнэлгээ</td><td colspan="7">Төслийн I шатны хүрээнд УТХГ-ын хамгаалалтын захиргааны менежментийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжсэн бол төслийн II,III шатанд өргөжиж, аймгийн БОАЖГ, нийслэлийн БОГ, УЦУОШТ, усны сав газар болон ойн анги зэрэг байгаль орчны бүхий холбогдох газрууд хамрагдаж байна.</td></tr>
<tr><td rowspan="4">13</td><td rowspan="4">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)</td><td rowspan="4">Биелэлт дундаж %</td><td>Менежмент</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td><td>Зорилт 3</td><td>Зорилт 4</td><td>БОННМ Мониторинг</td></tr>
<tr><td>100%</td><td>72,2%</td><td>65%</td><td>74,4%</td><td>78%</td><td>92,5%</td></tr>
<tr><td>Нийт 6 ажил: 6 ажил 100%</td><td>Нийт 10 ажил: 4 ажил 100%, 1 ажил 70%, 3 ажил 50%, 1 ажил 30%, 1 ажил үнэлэхгүй</td><td>Нийт 17 ажил: 9 ажил 100%, 2 ажил 70%, 5 ажил 0%,1 ажил үнэлэхгүй</td><td>Нийт 9 ажил: 6 ажил 100%, 1 ажил 70%, 2 ажил 0%</td><td>Нийт 7 ажил: 2 ажил 100%, 2 ажил 70 %, 1 ажил 50%, 2 ажил үнэлэхгүй</td><td>Нийт 5 ажил: 3 ажил 100%, 1 ажил 70%,1 ажил үнэлэхгүй</td></tr>
<tr><td colspan="6">2023 оны үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу нийт 58 ажил төлөвлөснөөс ТХН-ийн дотоод 4 ажлыг үнэлээгүй тул нийт 54 ажил.<br>Нийт 54 ажлаас ТХН-ийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар хэрэгжээгүй 5 ажлыг үнэлээгүй. Үүнд:<br>1. Төслийн барилгын хяналт, 2. Эрээн нуурыг сэргээх, 3. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг хийх, 4. Олон улсын туршлага судлах, 5. Хяналт, үнэлгээний мониторингийн сургалт хийх зэрэг ажлууд болно.<br>Үнэлсэн: Нийт 49 ажил.<br>100%-тай=30=3000 /үр дүнтэй, бүрэн хэрэгжиж дууссан/<br>70%-тай=7=490 /гэрээ хэрэгжих шатандаа, өөрсдөөс хамаарах шийдвэр гарсан/<br>50%-тай=4=200 /боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, гэрээ байгуулагдах шатандаа/<br>30%-тай=1=30 /боловсруулалтын шатандаа гэрээ байгуулагдах шатандаа/<br>7 ажил =0 /хийгдээгүй/<br>Үүнд: ОБ-ийн зээлийн эргэлтийн сангийн санхүүжилт гаргах 2 ажил, Баруун бүсийн төвийн барилгын концепци боловсруулах болон зураг төсөв гаргах 2 ажил, Говийн их ДЦГ-ын хамгаалалтын захиргааны байр барих 1 ажил, Байгаль хамгаалагчийн байр барих 2 ажил зэрэг болно.</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III төслийн үйл ажиллагааны хэрэгжилт 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар арифметик дунджаар 75.9 %-ийн биелэлттэй байна.** | | | | |
| 14 | ЗГХЭГ-ын үнэлгээ | Нэгдсэн үнэлгээ | | | | |
| | | ... % | | | | |
| **Нэмэлт мэдээлэл /сая төгрөгөөр/** | | | | | | |
| 15 | Зарцуулалт | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
| | ХБНГУ-ын Засгийн газар | | 2,257.18 | 3,353.03 | 6,626.60 | 11,428.4 |
| | МУ-ын Засгийн газар | 52.09 | 546.71 | 697.07 | 748.6 | 805.9 |
| 16 | Жендерийн мэдээлэл | Тус төсөл нь санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл бөгөөд 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд жендерийн ажил хийгдээгүй болно. | | | | |
| 17 | Суурь судалгаа хийгдсэн эсэх | "Сонгогдсон ТХГН-ийн биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх" зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг төслийн "БОЯБ-ын мэргэжлийн зөвлөл"-ийн гишүүдээр 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцүүлэн хүлээн авсан. | | | | |

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ М.БОЛДБАЯР

ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАН Ж.МӨНХТҮВШИН

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Ц.ЭНХСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ ТБАГ

## БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН 2023.12.31

*төгрөгөөр/евргөөр/*

| Орлого | Тайлант хугацаанд 2023.12.31 | | Өссөн дүнгээр | |
|---|---|---|---|---|
| | Евро | Төгрөг | Евро | Төгрөг |
| KfW | | | | |
| Шууд санхүүжилт(Зөвлөх) | | | 1,725,451.53 | 6,422,337,648.84 |
| Хярбаршуулсан шууд төлбөр | 1,108,706.86 | 4,204,099,661.23 | 1,108,706.86 | 4,204,099,661.23 |
| Татан төвлөрүүлэлтийн данс | 1,875,000.00 | 7,019,804,900.00 | 5,175,921.17 | 15,934,102,305.28 |
| KfW-орсон нийт санхүүжилт | 2,983,706.86 | 11,223,904,561.23 | 8,010,079.56 | 26,560,539,615.35 |
| Хүүгийн орлого | | | | |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | 229,450.90 | 870,000,000.00 | 1,140,690.75 | 4,245,787,854.39 |
| Нийт санхүүжилт/Орлого | 3,213,157.76 | 12,093,904,561.23 | 9,150,770.31 | 30,806,327,469.74 |
| Зардал | | | | |
| KfW | 2,953,067.23 | 11,428,370,180.10 | 6,451,191.62 | 19,944,110,151.80 |
| МУЗГ | 212,092.00 | 805,950,777.56 | 605,569.82 | 2,101,958,593.74 |
| МУЗГ-т буцаан шилжүүлсэн | | | | |
| Гадаад ханшийн зөрүү | | | | |
| Нийт зардал | 3,165,159.23 | 12,234,320,957.66 | 7,056,761.44 | 22,046,068,745.54 |
| Үр дүн | 1,566,544.37 | 5,845,559,480.05 | 1,566,544.37 | 5,845,559,480.05 |
| Урьдчилгаа | | | | |
| Цэвэр мөнгөн хөрөнгө | 1,566,544.37 | 5,845,559,480.05 | 1,566,544.37 | 5,845,559,480.05 |
| Эхний үлдэгдэл | | | | |
| KfW | | | | |
| Тусгай данс | 747,928.88 | 2,744,166,019.30 | | |
| Дэд данс | | | | |
| KfW-ний нийлбэр | 747,928.88 | 2,744,166,019.30 | - | - |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| Эхний үлдэгдлийн нийлбэр | 747,928.88 | 2,744,166,019.30 | - | - |
| Эцсийн үлдэгдэл | 1,566,654.37 | 4,005,033,808.59 | | |
| KfW | | | | |
| Тусгай данс | 1,056,274.51 | 4,005,033,808.59 | 1,056,274.51 | 4,005,033,808.59 |
| Дэд данс | | | | |
| KfW-ний эцсийн үлдэгдлийн нийлбэр | 1,056,274.51 | 4,005,033,808.59 | 1,056,274.51 | 4,005,033,808.59 |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| Эцсийн үлдэгдлийн нийлбэр | 1,056,274.51 | 4,005,033,808.59 | 1,056,274.51 | 4,005,033,808.59 |

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОН САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| № | Төслүүдийн нэр | Обьект, тоног төхөөрөмжийн нэр, байршил * | Хүчин чадлын нэгж** | Тоо хэмжээ *** | Төсөвт өртөг (мянган төгрөг) | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Ашиглалтад орж, хүлээн авсан, хүлээн авах он | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төсөл II, III | Кластерт хамрагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад болон байгаль орчны байгууллагуудыг шаардлагатай судалгааны багаж төхөөрөмжөөр хангах /ҮАТ 1.04./: | ш | 1923 | 2,585,823,868.94 | 2022 | 2023 | 2023 | Багц 1: "Судалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлын гэрээг 2022 онд "Өнө тэгш арвижих" ХХК-тай байгуулсны дагуу Ховд, Увс, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн байгаль орчны нийт 45 байгууллагын дарга, мэргэжилтэн нарт угсралт, суурилуулалт, ашиглалтын талаар онол, практикийн сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хийж, заавар, зөвлөмжийг өгч, гарын авлагаар хангаж, 691,982.86 еврогийн үнийн дүн бүхий 14 төрлийн нийт 1923 ширхэг тоног төхөөрөмжийг актаар хүлээлгэн өгсөн. |
| | | | ш | 4 | 396,068,610.77 | 2022 | 2023 | 2023 | Багц 2: "Цаг уурын автомат станц нийлүүлэх" ажлын гэрээг 2022 онд "АЧСВС" ХХК-тай байгуулсны дагуу Ховд, Увс, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн Ус, цаг уурын орчны шинжилгээний төвийн дарга, мэргэжилтэн нарт угсралт, суурилуулалт, ашиглалтын талаар онол, практикийн сургалтыг 2023 оны 04 дугаар сарын 06-ны өдөр хийж, заавар, зөвлөмжийг өгч, гарын авлагаар хангаж 104,396.00 еврогийн үнийн дүн бүхий 4 иж бүрдэл цаг уурын автомат станцыг актаар хүлээлгэн өгсөн. |
| 2 | | Цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангах ажил /ҮАТ 2.07/: | ш | 120 | 574,147,000.00 | 2022 | 2023 | 2023 | Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Баянхонгор, аймгийн БОАЖГ-т 3 нэр төрлийн 15 ш, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий аймгийн сумдад 3 нэр төрлийн 95 ш, Говь-Алтай аймгийн ИТХ, Увс аймгийн ЗДТГ тус тус 4 нэр төрлийн 4 ш, БОАЖЯ 2 төрлийн 2ш зэрэг 574,147,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 7 нэр төрлийн 120 ширхэг ухаалаг дэлгэц, дууны өсгөгч, ухаалаг дэлгэцийн хөл, вэб камерийн ком, лед дэлгэц, лед дэлгэцийн удирдлага, зөөврийн компьютер зэрэг цахим хурлын тоног төхөөрөмжийг 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 16 хоногийн хугацаанд баруун 5 аймаг, 30 сум тус бүрд тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан шалгаж, нийт 38 байгууллагын 159 албан хаагчид тоног төхөөрөмжийн танилцуулга хийж, цаашдын ашиглалттай холбогдох заавар, зөвлөмж өгч сургалт зохион байгуулан хүлээлгэн өгсөн. |
| 3 | | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажил /ҮАТ 2.03/ | ш | 3225 | 1,822,034,038 | 2023 | 2023 | 2024 | БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/245 дугаартай гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай тушаалын дагуу "Хашхан" ХХК-тай 480,315.61 еврогийн үнийн дүн бүхий 23/161 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан. Гэрээний дагуу нийлүүлэх 9 нэр төрлийн 3225 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг үйлдвэрлүүлэн тээвэрлэлтэд шилжүүлж, Хашхан ХХК-иас ирүүлсэн эхний санхүүжилтийн хүсэлтийг шалгаж баримт бичгийн бүрдэл дутуу байгааг мэдэгдээд гүйцээж ирүүлснээр санхүүжилт олгох болно гэж хэлээд санхүүд 2023.11.21-ний өдөр шилжүүлсэн. |
| 4 | | Төсөлд хамрагдсан сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчид болон бусад тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын ажилтнуудыг 4 улирлын дүрэмт (919) хувцсаар хангах ажил /ҮАТ 1.07/: | ш | 919 | 2,430,890,000.00 | 2022 | 2023 | 2023 | "ТХГН-ийн ХЗ, БОАЖГ-ын албан хаагчдыг 4 улирлын дүрэмт хувцсаар хангах" MONNCB-04/22, 22/373 дугаартай гэрээний дагуу 17 төрлийн 11995 ширхэг хувцас, гутлыг ТХГН-ийн ХЗ болон баруун 5 аймгийн БОАЖГ болох БО-ны нийт 32 байгууллагын 919 албан хаагчдад хүлээлгэн өгсөн. |
| 5 | | Төсөлд хамрагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад болон байгаль орчны байгууллагуудыг шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжөөр хангах /ҮАТ 1.05./: | ш | | 1,750,000,000.00 | 2023 | 2023 | 2023 | "Төсөлд хамрагдсан байгаль орчны байгууллагууд, бусад тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжөөр хангах" 23/144 дугаар гэрээтэй "Ай Си Ай систем Монголиа" ХХК-д гэрээний үнийн дүнгийн 60% буюу төгрөгийн эхний санхүүжилтийг олгоод байна. |
| | | | ш | 208 | 284,419,000 | 2022 | 2023 | 2023 | Багц 2:"Оффисын тавилга, IT тоног төхөөрөмж нийлүүлэх": БОАЖЯ, Дарьгангын БЦГ, Ачит нуур-Дэвэл арлын БЦГ, Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ, Тэсийн гол-Булнайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа зэрэг нийт 5 БО-ны газарт 284,419,000 төгрөгийн үнийн дүн бүхий 11 нэр төрлийн 208 ширхэг оффисын тавилга, IT тоног төхөөрөмжийг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр актаар хүлээлгэн өгсөн. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төсөл II, III | Байгаль орчны байгууллагуудад бартаат замын автомашин нийлүүлэх ажил /ҮАТ 1.08./:/ҮАТ 3.02/: | ш | 16 | 3,024,648,000.00 | 2023 | 2023 | 2024 | БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 03/3855 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Майнс ап" ХХК-тай 792,000.0 еврогийн үнийн дүн бүхий 23/150 дугаартай гэрээг 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан бөгөөд гүйцэтгэлийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 16 ширхэг Ниссан Патрол У61 Grx загварын автомашинуудын үйлдвэрлэлийн процесс дуусаж, далайн тээврийн ачилт эхлэх хуваарийг хүлээж байна.<br>БНХАУ-ын Шинганг далайн боомтод задгай тээврээр ирсэн ачаа, бараануудад Улаанбаатар болон бусад эцсийн чиглэл рүү тээвэрлэлт хийх чингэлгийн хүрэлцээгүйгээр ачаа тээврийн үйл явц энгийн үеийнхээс 2-3 дахин удаашралтай явагдаж байгааг нийлүүлэгчээс мэдэгдэж 2 удаагийн уулзалт зохион байгуулсан ба 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн АБ-23/1062 дугаартай албан бичгээр гэрээний хугацааг 90 хоногоор буюу 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл сунгах хүсэлтийг захиалагчид ирүүлсэн. |
| 7 | | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах ажил /ҮАТ 2.05/,/ҮАТ 3.07/: | ш | 200 | 1,127,225,600 | 2023 | 2023 | 2024 | БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 03/4574 дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн дагуу "Протек" ХХК-тай 1,127,225,600.0 төгрөгийн үнийн дүн бүхий 23/172 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 200 ширхэг Yamaha YBR-125EGS загварын мотоцикл тээвэрлэлтэд шилжсэн ба 2023 оны 12 сарын 22-нд гаалийн талбайд буух төлөвлөгөөтэй байгаа ба мотоциклд дагалдах хамгаалалтын хэрэгсэл болох 200 ширхэг дуулга, 200 ширхэг өвдөгний хамгаалалт гаалийн талбайд бэлэн ирсэн тул баримт бичгийг үндэслэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэхээр ажиллаж байна. |
| 8 | | Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, трактор, хогны машин, бохир соруулах машин) ажил /ҮАТ 2.10/, /ҮАТ 3.03/: | ш | 19 завь, 3 UTV, 275 ш дагалдах хэрэгсэл | 688,675,440.00<br>1,766,881,076 | 2023 | 2023 | 2024 | "Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан.<br>1-р багц: "Протек" ХХК-тай 183,709.0 еврогийн үнийн дүн бүхий 23/177 дугаартай бараа нийлүүлэх гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд завь, 4 дугуйт мотоцикл нийлүүлэхээр гэрээнд заасан.<br>Гэрээний дагуу нийлүүлэх 3 төрлийн 19 ширхэг завь болон 3 ширхэг дөрвөн дугуйт мотоцикл, 275 ширхэг дагалдах тусгай хэрэгслийн захиалгууд хийгдэж үйлдвэрлэл явагдан дусаж байна. Хуваарийн дагуу 2023 онд багтаан тээвэрлэлтэд шилжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>2-р багц: МБ инжиниринг ХХК-тай 471,327.91 евро буюу 1,766,881,076 төгрөгийн үнийн дүн бүхий "Машин, трактор" нийлүүлэх гэрээг 150 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд гэрээний дагуу нийлүүлэх 11 ширхэг өөрөө буулгагч автомашин, 4 ширхэг бохир соруулах автомашин, 7 ширхэг трактор, дагалдах 22 ширхэг агрегат, тоног төхөөрөмжийг үйлдвэрлүүлэн тээвэрлэлтэд шилжүүлсэн байна. Гэрээний дагуу машин, тоног төхөөрөмжийг тээвэрлэлтэд шилжүүлсэн баримт бичигт үндэслэн эхний санхүүжилтийг олгоод байна. |
| 9 | | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажил /ҮАТ 2.04/, /ҮАТ 3.06/: | ш | 17 | 2,142,459,000.00 | 2023 | 2023 | 2024 | Тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. Захиалагч тендерт шалгарсан "Мөнххада" ХХК-тай 17 эмнэлгийн түргэн тусламжийн автомашиныг 240 хоногийн хугацаанд 935,000 еврогоор нийлүүлэх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан. |
| 10 | | Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих гүйцэтгэгч сонгох ажил /ҮАТ 2.08/: | м2 | | | 2023 | 2024 | 2024 | Гэрээ байгуулах шатандаа |
| 11 | | Хамгаалалтын захиргаадын барилгын нэмэлт ажил /ҮАТ 2.09/: | м2 | | | 2023 | 2023 | 2024 | Концепц боловсруулах шатандаа |
| 12 | | Баруун бүсийн сургалт судалгаа, мэдээллийн төвийн барилга барих ажил /ҮАТ 2.01/: | м2 | | | 2023 | 2023 | 2024 | Концепц боловсруулах шатандаа |
| 13 | | Байгаль хамгаалагчийн 12 байр барих ажил /ҮАТ 2.06/,/ҮАТ 3.08/: | м2 | | | 2023 | 2023 | 2024 | Зураг төсөл боловсруулах шатандаа |

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХУВИЙН ХЭВШИЛ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖСЭН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

| № | Төслүүдийн нэр | Төслийн хүрээнд зээл олгож, батлан даалт гарган, санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн нийт хэмжээ сая.төгрөг (өссөн дүнгээр) * | | Үүнээс 2022 онд зээл олгож, батлан даалт гарган, санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн хэмжээ сая.төгрөг (өссөн дүнгээр) | | Төслийн хүрээнд 2023 онд зээл олгож, батлан даалт гарган, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх хэмжээ сая.төгрөг (өссөн дүнгээр) | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ААН-ийн тоо | Мөнгөн дүн | ААН-ийн тоо | Мөнгөн дүн | ААН-ийн тоо | Мөнгөн дүн |
| 1 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төсөл II, III | 0 | - | 0 | - | 0 | - |

* Төсөл эхэлснээс хойш зээл олгож, батлан даалт гарган, санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн нийт хэмжээ